

“ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

2020 оны 2-р сарын 14

№ ТУЗ-20/1

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61.1.5, 67.1, 71.3, 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14 ны өдрийн 377 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам”, Глобал лайф технологи ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2020 оны 2-р сарын 14-ны өдрийн “Төлөөлөн удирдах зөвлөл”-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 3 сарын 30- ны өдрийн Даваа гарагт 10:00 цагт “Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Мандал хотхон, 42-11 тоот” хаягт зарлан хуралдуулсугай.
2. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 3 сарын 6-ны өдрөөр тогтоосугай.
3. Хувьцаа эзэмшигчдэд ээлжит хурлын материалыг 2020 оны 2 сарын 21-ний өдөр үнэт цаасны компанид цахим шуудан болон бичгээр илгээх ба хувьцаа эзэмшигчид компанийн байранд дээрх өдрөөс хойш ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд ирж танилцаж болохыг түгээсүгэй.
4. Бичгээр санал авах хуудсыг хүлээж авах сүүлийн хугацааг 2020 оны 3 сарын 27-ны өдрөөр тогтоож, компанийн байранд авахаар тогтоосугай.
5. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2020 оны 2 сарын 19-ний өдөр болон, давтан 15 хоногийн дараа буюу 3 сарын 5- ны өдрөөр тогтоож, зарын агуулгыг “хавсралт №3”-оор баталсугай..
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар Компанийн ТУЗ-ийн гишүүн П. Очирхуяг-г томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн ТУЗ-ийн гишүүн П. Очирхуяг -г томилсугай.
8. Хурлын тооллогын комиссын даргаар Б.Батцэцэг-г, гишүүнээр Э.Анхбат нарыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг “хавсралт №1”-ээр баталсугай.

“ГЛОБАЛ ЛАЙФ ТЕХНОЛОГИ ХК

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг “хавсралт №2”-аар баталсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал авах хуудсыг “хавсралт №4”-өөр баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/YEN MONTGOMER/